



14

БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 3 сарын 08

№ 65

Улаанбаатар
хот

УТ 1991 он 315

Хөдөлмөр эрхлэлтийн газар
байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ
НБ:

1. Ажилч-үйчүүдийн эрхийг хамгаалах хөдөлгөөний санаачилгыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны харьяанд Хөдөлмөр эрхлэлтийн газрыг байгуулж хотын хөдөлмөрийн зах, гүйцэтгэх захиргааны хувийн үйлдвэрийн асуудал эрхэлсэн товчоог харьяалуулж ажиллуулсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийн газрын цалингийн санг 27,6 мянган төгрөгөөр тогтоосугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийн газарт даалгах нь:

а/ Ижиг, дунд үйлдвэр зохион байгуулах, ажил эрхлээгүй хүмүүст дэмжлэг үзүүлэх, ажлын байр шинээр бий болгох зорилгоор байгуулсан санг Улаанбаатар хотын хэмжээнд хуваарилах, үр ашигтай зарцуулах асуудлыг хариуцан тухай бүр Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд оруулж шийдвэрлүүлж байсугай.

б/ Улаанбаатар хотын хэмжээнд ижиг үйлдвэр, хоршоо, пүүс байгуулах, бүртгэх, зөвлөлтөө өгөх, зуучлах асуудлыг дүүрэг, хорооны Ардын Хурлын гүйцэтгэх захиргаадтай хамтран зохион байгуулж байсугай.

в/ Мэргэжилтэй боловсон хүчин, ажилчин бэлтгэх, давтан сургуурэг бүхий сургалтын төвийг өөрийн харьяанд байгуулж ажиллуулах зөвшөөрсугай.

4. Хөдөлмөр эрхлэлтийн газрын үйл ажиллагааны зардлыг ажил эрхлээгүй хүмүүст дэмжлэг үзүүлэх, ажлын байр шинээр бий болгох сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүүгийн газар, Хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэст зөвшөөрсүгэй.

2.

5. Улаанбаатар хотод жижиг үйлдвэр хөгжүүлэх хөтөлбөрийг 1991 оны II улиралд багтаан боловсруулж Нийгэм эдийн засгийн бодлогын өөрчлөлдөөр хэлэлцүүлэн хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд оруулахыг Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хот байгуулалт төлөвлөлтийн газар, Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтэст тус тус цаалгасугай.

6. Хөдөлмөр эрхлэлтийн газарт албан байр гаргаж өгсхийг Өмчийн газар /н.Найдан/-т цаалгасугай.

7. Хөдөлмөр эрхлэлтийн газар, Хөдөлмөр нийгэм хангамжийн хэлтсийн дүрмийг энэ оны 4 дүгээр сард багтаан боловсруулж хотын гүйцэтгэх захиргаанд оруулахыг тэргүүн нэд дарга Г.Ганхуягт цаалгасугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулж Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны "Хотын ажил эрхлээгүй яргадийт ажлын байраар хангах тухай" 1991 оны 341 дүгээр тогтоолын 2,5 дугаар заалт, "Хөдөлмөрийн зах байгуулах тухай" 1990 оны 273 дугаар тогтоолын 1,3,4 дүгээр заалт, "Хувийн үйлдвэр нүүс байгуулах эрх олгох, бүртгэх журмын тухай" 1990 оны 272 дугаар тогтоолын 1,2,4,5 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

[Signature]
Л. ЭНЭБИШ

[Signature]
Ч. СУМААХҮҮ